



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 9/82

Мандалговь

Г Бүтээлч аян зарлах тухай Т


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "л", Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн A/01 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилготой "Мандалговь-55" бүтээлч аяны удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Аянд идэвх санаачлагатай оролцохыг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт, аяныг чанартай зохион байгуулж, үр дүнг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Р.Мөнхтогтох)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

Дөрөв. Бүтээлч аянд идэвх гаргаж үр бүтээлтэй оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг урамшуулахад шаардагдах 9.900.000 (есөн сая есөн зуун мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодогч (С.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.



482010253

Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн 18-дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

“МАНДАЛГОВЬ-55”
БҮТЭЭЛЧ АЯНЫ УДИРДАМЖ

2020.03.18

Мандалговь хот

Нэг. Уралдааны зорилго

1. Иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад аяны зорилго оршино.

Хоёр. Уралдааны хамрах хүрээ

- 2.1. Мандалговь хотын нутаг дэвсгэр дэх Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүд хамрагдана.

Гурав. Шалгуур үзүүлэлт

3.1 Төрийн байгууллага

- 3.1.1 Гадна, дотор орчны ногоон тохижилтыг хийж гүйцэтгэсэн байх. Үүнд:

- Гадна орчноо цэцэрлэгжүүлэх. Үүнд урьд онд хийгдсэн ногоон байгууламж хамаарахгүй. /Зулэг, мандлын цэцэг, ургамлан хашлага болон гоёлын мод суулгац тарих гэх мэт/

- Ажилчдын өрөө тасалгаа, хурлын танхим, үүдний танхим, коридор болон бусад орчинд тасалгааны олон наст цэцэг тарих. /ажилчдын тооноос цөөнгүй байх бөгөөд тусгайлан бэлтгэсэн цэцгийн тавиур дээр байрлуулсан байх/

- 3.1.2 Гадна, дотор орчны хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар бүтээлч болон нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн байх.

- Ажилчдын өрөө тасалгаа, хурлын танхим, үүдний танхим, коридор, гадна хаалга болон бусад орчинд АНГИЛАН ЯЛГАХ ЗОРИУЛАЛТ бүхий хог хаягдлын сав байршуулах. /БОАЖГ-аас өгсөн ангилан ялгах хогийн савны засвар, стандартын дагуу хамт олноороо бүтээлчээр хандаж, тогтоосон нэг загвараар дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийсэн байх/

- 3.1.3 Байгууллага гадна тэмдэг тэмдэглэгээ, камержуулалтыг иж бүрэн шийдсэн байх.

- 3.1.4 Барилга байгууламжийн гадна фасад, дээвэр, хашаа хамгаалалтын өнгө үзэмжийг засварлах, шинэчлэх.

- 3.1.5 Байгууллагын гадна фасад болон 50 м орчныг гэрэлтүүлэх гарэл хийх. (Хотын шөнийн өнгө үзэмж орчны гэрэлтүүлгийг сайжруулах зорилгоор)

- 3.1.6 Авто машины зогсоолын тохижилт хийсэн байх. Бетон болон эко хавтан ашиглах. (10cm багагүй зузаан, эко хавтанг шугам сүлжээтэй газарт хийх)

3.2. Аж ахуйн нэгж

- 3.2.1 Гадна, дотор орчны ногоон тохижилтыг хийж гүйцэтгэсэн байх. Үүнд:

- Гадна орчноо цэцэрлэгжүүлэх. Энэ нь урьд онд хийгдсэн ногоон байгууламж хамаарахгүй. /Зулэг, мандлын цэцэг, ургамлан хашлага болон гоёлын мод суулгац тарих гэх мэт/

- Ажилчдын өрөө тасалгаа, хурлын танхим, үүдний танхим, коридор болон бусад орчинд тасалгааны олон наст цэцэг тарих. /ажилчдын тооноос цөөнгүй байх бөгөөд тусгайлан бэлтгэсэн цэцгийн тавиур дээр байрлуулсан байх/

3.2.2 Гадна, дотор орчны хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар бүтээлч болон нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн байх.

□ Ажилчдын өрөө тасалгаа, хурлын танхим, үүдний танхим, коридор, гадна хаалга болон бусад орчинд **АНГИЛАН ЯЛГАХ ЗОРИУЛАЛТ** бүхий хог хаягдлын сав байршуулах. /БОАЖГ-аас өгсөн ангилан ялгах хогийн савны заавар, стандартын дагуу хамт олноороо бүтээлчээр хандаж, тогтоосон нэг заавараар дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийсэн байх/

3.2.3 Байгууллага гадна хаяг, тэмдэг тэмдэглэгээ, явган хүний зам, камержуулалт тохижилтыг иж бүрэн шийдсэн байх.

3.2.4 Барилга байгууламжийн гадна фасад, дээвэр, хашаа хамгаалалтын өнгө үзэмжийг засварлах, шинэчлэх.

3.2.5 Байгууллагын гадна фасад болон 50 м орчныг гэрэлтүүлэх гарэл **хийх**. (**Хотын шөнийн өнгө үзэмж орчны гэрэлтүүлгийг сайжруулах зорилгоор**)

3.2.6 Авто машины зогсоолын тохижилт хийсэн байх. Бетон болон эко **хавтан ашиглах**. (10см багагүй зузаан, эко хавтанг шугам сүлжээтэй газарт **хийх**)

3.3 Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай айл өрх

Орчны тохижилт, ногоон байгууламж нь бусдад загвар болохуйц, шинэлэг, айл өрхүүд нь суманд хэрэгжиж байгаа жишиг хашаа гудамжтай өнгө, загварын хувьд ижил хэмжээтэй байна. Айл өрх бүр хашаагаа тогтоосон шугамд цэгцлэн тэгшилж, хаалгаа шинэчлэн будаж шохойдсон байна.

3.3.1 Эзэмшил газартаа ногоон байгууламжийн талбайг шинээр бий болгох, нэмэгдүүлэх. Үүнд: 5 ш доошгүй мод, 10м² цэцэгт мандал, бусад

3.3.2 Хашааг улаан хүрэн өнгөөр, хүрээ модыг цагаанаар, **хаалга** ногоон өнгөөр, хээ угалзыг цагаан өнгөөр.

3.3.3 Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байрлуулж, хогоо ангилж **хэвшсэн** байна. (Унсний савийг тагтай 1x1.5x1.2 харьцаатай блокоор барих шал нь бетон, хаалга хашааны гадна талд гаргах.)

3.3.4 Хашааныхаа газар талбайг үр дүнтэй ашиглаж, ногоон байгууламжтай талбайгаас бусад хэсгүүдэд гэрэлтүүлэг, явган хүний зам, хайргаар авто зогсоол **хийх** зэрэг орчны тохижилтыг хийсэн байх

3.3.5 Бие засах газар муу усны нүхний зохион байгуулалт шийдлийг байгальд ээлтэй байдал (ЭКО ЖОРЛОН)-аар шийдвэрлэж, стандартын дагуу **тохижуулан ариутгал** цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн байх.

3.3.6 Хэрэв нохойтой бол хаалган дээрээ тодорхой анхааруулга байрлуулах өдрийн цагаар богиносгосон уяанд, шёнийн цагт уртасгасан уяанд тогтмол уяж, нохайн байртай байх.

3.3.7 Аюулгүй байдлыг хангах зорилгоор дотор, гадна орчны камержуулалтыг **хийх**.

Дөрөв. Аян зарлах, дүгнэх хугацаа

4.1 Бүтээлч аяны хугацаанд нь хийгдсэн тохижилт, ногоон байгууламжийн талаар танилцуулга, ажил эхлэхийн өмнөх, дунд, дараа үед нь зургаар баталгаажуулан альбом хийж зарцуулсан төсөв гарган файлт хэлбэрээр өгөх.

Бүтээлч аян 2020 оны 05 дугаар сарын 01-нээс 2020 оны 09 дүгээр сарын 15-нийг хүртэл үргэлжилнэ.

4.2 2020 оны 09 дүгээр сарын 01-ээс 10-ны хооронд тайланг хүлээн авч, 09 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд дүгнэж шалгаруулна. Тайланг Хот тохижуулах газар (С.Цэрэн 70593906, 99596333)-т хүлээн авна.

Тав. Шагнал урамшуулал

5.1 Болзлыг бүрэн биелүүлж шилдгээр шалгарсан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг тус бүр өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

НИЙТ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Зардал ₮
1	Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА	3	1.000.000	3000.000
2	Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай АЖ АХУЙН НЭГЖ	3	1.000.000	3000.000
3	Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай АЙЛ ӨРХ	5	500.000	2.500.000
4	Өргөмжлөл	15	60.000	900.000
5	Орон нутгийн телевизээр олон нийтэд сурталчлах	-	500.000	500.000
Нийт дүн				9.900.000

ЖИЧ:

- 1.Түрүүлсэн айл өрх, ААНБ-ыг аймгийн хүндэт шагналаар шагнах.
2. Оролцогчдод Мандалговь 55 дурсгалын тэмдэг гардуулан алдаршуулна.

Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 10.-ны өдрийн 12. дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

“МАНДАЛГОВЬ-55”

БҮТЭЭЛЧ АЯНЫ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Р.Мөнхтогтох (Сайнцагаан сумын Засаг дарга бөгөөд
Мандалговь хотын Захирагч)

Нарийн бичгийн дарга: Х.Анхбаяр (Хот тохижуулах газрын дарга)

Гишүүд:
Б.Рэнцэндорж (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын хэлтсийн дарга)

Э.Уянга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн)

Б.Саранзаяа (Худалдаа үйлдвэрлэл хариуцсан
мэргэжилтэн)

Ж.Миеэсүрэн (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

С.Цэрэн (Хот тохижуулах газрын мэргэжилтэн)